



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Компанийн зохион байгуулалтын
бүтцийг шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалт, “Эрчист монгол” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн удирдамж хүргүүлэх тухай 01/289 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын нэр, орон тооны жагсаалтыг 30 хоногийн дотор шинэчлэн батлан, мөрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхагва-очир)-т үүрэг болгосугай.

3. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Л.Амгалан)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА



"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨХХК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

